Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

Дээд боловсролын газар

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | Өөрийн үнэлгээ | ХШҮ |
| Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ | | | | | | | | | |
| 1.1. | Дижитал шилжилт, технологийн өөрчлөлт, шинэчлэлийн сорилтыг даван туулах чадвартай, монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч хүмүүжлийг олгох боловсролын үндэсний | - | - | - | - | | Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн "Нийтлэг шаардлага шинэчлэн батлах тухай" А/147 дугаар тушаалаар батлагдсан "Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага"-ыг 2024-2025 оны хичээлийн жилийн сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Дээд боловсролын сургалтын байгууллагууд сургалтын хөтөлбөрөө 2023 оны шинэчлэгдсэн багц хууль болон 2024 оны "Дээд боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрийн | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөтөлбөрийг хөгжүүлнэ. | | | | | | нийтлэг шаардлага'-д нийцүүлэн бүрэн шинэчлэн боловсруулсан эсэхийг 14 дээд боловсролын сургалтын байгууллагын 32 өөр төрлийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, БМИҮЗ-өөс гаргасан дүгнэлт зэргийг түүврийн аргаар авч шалгаж, судалгаа хийж үзсэн. Судалгаанд МУИС, ШУТИС, МУБИС, Мандах ИС, ОУУБИС, Өмнөговь ТДС, Сити ИС, СЭЗИС, Шихихутуг ИС, Монгол Коосэн коллеж, Шинэ Ионгол ТДС, Шинжлэх ухааны академи их сургууль, Чингис хаан ДС гэсэн 14 сургалтын байгууллага хамрагдсан. Монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч хүмүүжлийг олгох нийтлэг агуулга эдгээр хөтөлбөрүүдэд тусган боловсруулсан байна. Хавсралт: 3 файл | | |
| 1.1.1 | Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт Монголын түүх, хэл, | - | Монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, | - | - | 8 | Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн "Нийтлэг шаардлага шинэчлэн батлах тухай" А/147 дугаар тушаалаар | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч хүмүүжлийг олгох нийтлэг агуулгыг тусгаж хэрэгжүүлнэ. | | эх оронч хүмүүжлийг олгох нийтлэг агуулгыг тусган хөтөлбөрийн тоо | | | | батлагдсан "Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага"-д дээд боловсролын ерөнхий суурь хэсгийн суралцахуйн үр дүнгийн "Хүмүүнлэгийн ухааны" агуулгын чиглэлд түүх, соёл, гүн ухаан, урлаг, гоо зүйн сэтгэлгээг хөгжүүлэх, хүний эрх, жендерийн эрх тэгш байдал, иргэний ёс зүй болон зан төлөв, хүмүүнлэг иргэн, тогтвортой хөгжил, эх хэлээр утга төгс ярих, илтгэх, найруулан бичих, эрдэм шинжилгээний бичлэгт хэрэглэх мэдлэг ойлголтыг хэрэглэх чиглэлийг 6+ багц цаг судлахаар журамд тусгасан. Үүний дагуу дээд боловсролын сургалтын байгууллагууд тус журамд заасны дагуу 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө сургалтын хөтөлбөрөө тус нийтлэг шаардлагад нийцүүлэн шинэчлэн баталж, 2024-2025 оны хичээлийн жилийн сургалтын үйл ажиллагаag хэрэгжүүлж байна. Дээд боловсролын сургалтын байгууллагууд сургалтын хөтөлбөрөө 2023 оны шинэчлэгдсэн багц хууль болон 2024 оны | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | "Дээд боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрийн нийтлэг шаардлага'-д нийцүүлэн бүрэн шинэчлэн боловсруулсан эсэхийг 14 дээд боловсролын сургалтын байгууллагын 32 өөр төрлийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, БМИҮЗ-өөс гаргасан дүгнэлт зэргийг түүврийн аргаар авч шалгаж, судалгаа хийж үзсэн. Судалгаанд МУИС, ШУТИС, МУБИС, Мандах ИС, ОУУБИС, Өмнөговь ТДС, Сити ИС, СЭЗИС, Шихихутуг ИС, Монгол Коосэн коллеж, Шинэ Ионгол ТДС, Шинжлэх ухааны академи их сургууль, Чингис хаан ДС гэсэн 14 сургалтын байгууллага хамрагдсан. Монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч хүмүүжлийг олгох нийтлэг агуулга эдгээр хөтөлбөрүүдэд тусган боловсруулсан байна.<br>Хавсралт: 3 файл | | |
| 1.2. | Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг их өгөгдөлд | - | - | - | - | | Мега төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах мэргэжлийн чиглэлээр дотоодын дээд | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | суурилан тооцоолж, шаардлагатай хүний нөөцийг бэлтгэнэ. | | | | | | боловсролын сургалтын байгууллагуудад 2024-2025 оны хичээлийн жилд нийт 18,209 суралцагч суралцаж байна. Үүнээс төрийн өмчийн 12 сургалтын байгууллагад 13,003, төрийн бус сургалтын байгууллагад 5,206 суралцагч суралцаж байна. Дээд боловсролын тэгүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлийн жагсаалтыг шинэчлэн боловсруулаад Боловсролын сайдын 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн "Санал авах тухай" 1/1084 тоот албан бичгээр Засгийн газрын тогтоолын төсөлд санал авч, нийт 18 яам, УИХ-ын гишүүн, Мэргэжлийн холбооноос санал ирүүлснийг нэгтгэсэн. Яамдаас хөтөлбөрт нэмэлт санал ирүүлсэн тул тус хөтөлбөрүүдийн хөдөлмөр эрхлэлтийн эрэлтийн судалгааг нэмж хийн дүгнэлт гарган яамны удирдлагад танилцуулахаар бэлэн болгож бэлтгэв.<br>Хавсралт: 4 файл | | |
| 1.2.1 | Хөдөлмөрийн зах зээлийн | - | Мега төслийг хэрэгжүүлэх | 12,000 | 12,050 | 12,100 | 1.Боловсролын сайдын 2024 оны "Босго оноог | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | эрэлт, ур чадварын шаардлагад нийцсэн хүний нөөцийг дотоод, гадаадын их сургууль, коллежид бэлтгэнэ. | | эд шаардагдах мэргэжлийн чиглэлээр мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй суралцагчийн тоо | | | | тогтоох тухай" 228 дугаар тушаалаар Мега төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах мэргэжлийн чиглэлээр элсэгчдийн босго оноог эрэлттэй нийцүүлэн тогтоосон. 2.Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 215 дугаар тогтоол батлагдсан. Тус тогтоолд тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр суралцагчид тэтгэлэг олгох зохицуулалт 5 дугаар зүйлд шинэчлэгдэн туссан. 3.Ерөнхийлөгчийн дэргэд Цагаан алт хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх эрдэмтдийн зөвлөлд орж хүний нөөцийг бэлтгэх хүрээнд ажиллаж байна. 4."Цагаан алт" үндэсний хөдөлгөөний хүрээнд Хүний нөөц бэлтгэх, чадавхжуулах Дэд ажлын хэсгийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/120 тоот тушаалаар байгуулсныг Ажлын хэсэгт орж ажиллаж холбогдох судалгааг хийж байна. 5.Ерөнхий боловсролын төгсөх ангийн сурагчид, оюутнууд болон сонирхсон иргэдэд дотоодын болон гадаадын их, дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | (МСҮТ), сургалтын төвүүдийн талаар бодит, шууд мэдээлэл олгох, мэргэжлээ зөв сонгоход нь дэмжлэг үзүүлэх, боловсролын чиг баримжаа олгох зорилготой 2025 оны 05 сарын 19, 20-ны өдөр Жанжин Д.Сүхбаатарын талбайд Нийслэлийн засаг даргын тамгын газар, Боловсролын яам хамтарсан арга хэмжээг зохион байгуулж ажилласан. 5.Дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагуудад 2024-2025 оны хичээлийн жилд нийт 18,209 суралцагч суралцаж байна. Үүнээс төрийн өмчийн 12 сургалтын байгууллагад 13,003, төрийн бус сургалтын байгууллагад 5,206 суралцагч суралцаж байна 6. Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад тэргүүлэх чиглэлээр нийт 429 суралцагч тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламжид хамрагдан суралцаж байна. Тэдгээрээс Ерөнхийлөгчийн тэтгэлэгт 177, дэлхийн шилдэг их сургуульд зээлээр 169, Засгийн газар хоорондын гэрээгээр 81 суралцагч хамрагдсан. Боловсролын | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | түвшингээр нь авч бакалаврт 290, магистрт 78, докторт 61 суралцагч байна. Хавсралт: 5 файл | | |
| 1.2.2 | Монгол Улсыг хөгжүүлэхэд шаардлагатай дээд боловсролын тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлийн хөтөлбөрийн жагсаалтыг шинэчлэн боловсруулна. | - | Засгийн газрын тогтоолын төсөл | Засгийн газрын 2023 оны 115 дугаар тогтоол | Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулсан байна. | - | Монгол Улсыг хөгжүүлэхэд шаардлагатай дээд боловсролын тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлийн хөтөлбөрийг Монгол улсын Засгийн газрын 2023 оны 115 дугаар тогтоолоор баталж, энэ нь Боловсролын ерөнхий хуулиар 5 жил тутам шинэчлэгдэх зохицуулалттай байдаг. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн "Аргачлал батлах тухай" А/259 дугаар тушаалаар "Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/ тодорхойлох аргачлал" батлагдсан. Үүний хүрээнд Боловсролын сайдын 2024 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/120 дугаар тушаалаар "Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн жагсаалтын төсөл боловсруулах ажлын хэсэг" байгуулсан. Ажлын | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэсгийн хүрээнд тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэл тодорхойлох аргачлалын дагуу хүснэгтийг зохиож, томьёонд оруулж дээд боловсролын сургалтын 65 байгууллагад хүргүүлэн Санал авсан. Ингэхдээ тухайн сургуулийн санал болгож буй мэргэжлийн хөтөлбөр нь Монгол улсын бодлогын ямар баримт бичигт туссан, түүний хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээг тодорхойлох зэрэг үзүүлэлтийг томьёонд оруул, тооцоолох бүрэн боломжтой загварыг бэлтгэн хүргүүлсэн. Сургуулиас ирүүлсэн саналыг судалж дээд боловсролын тэгүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлийн жагсаалтыг шинэчлэн боловсруулаад Боловсролын сайдын 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн "Санал авах тухай" 1/1084 тоот албан бичгээр Засгийн газрын тогтоолын төсөлд санал авахаар холбогдох яамдад хүргүүлсэн. Нийт 18 яам, УИХ-ын гишүүн, Мэргэжлийн холбооноос санал ирүүлснийг нэгтгэсэн. Яамдаас | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөтөлбөрт нэмэлт санал ирүүлсэн тул тус хөтөлбөрүүдийн хөдөлмөр эрхлэлтийн эрэлтийн судалгааг нэмж хийн дүгнэлт гарган яамны удирдлагад танилцуулахаар бэлэн болгож бэлтгэв. Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлийн хөтөлбөрийн жагсаалтыг шинэчлэн боловсруулаад байна.<br>Хавсралт: 7 файл | | |
| 1.3. | Боловсролд бүх хүүхэд, залуучуудыг тэгш хамруулах зарчмыг баримталж, ялгаатай хэрэгцээтэй хүүхэд, залуучуудыг хамруулсан, тэдний гэр бүл, орон нутгийн онцлог байдалд нийцсэн, тохируулгат орчин, дэд бүтэцтэй, хувилбартай, | - | - | - | - | | Дээд боловсролын байгууллагын 91.4 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад үйлчилгээ үзүүлэх орчны нөхцөлийг өөрийн нөөц боломжид тулгуурлан шийдсэн байна. 2024-2025 оны хичээлийн жилд Их, дээд сургууль, коллежид нийт 150,282 суралцагч суралцаж байгаа бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй 436 суралцагч байгаа нь 0.3 хувийг эзэлж байна.<br>Хавсралт: 2 файл | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | гэрийн сургалттай боловсролын үйлчилгээг бүх түвшинд бий болгоно | | | | | | | | |
| 1.3.1 | Ялгаатай хэрэгцээтэй иргэдийг дээд боловсролын сургалтын байгууллагад суралцах боломжийг нэмэгдүүлнэ. | 2,616.20 | Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувь | 0.3 | 0.3 | 0.4 | Боловсролын сайдын 2025 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/03 дугаар тушаалаар батлагдсан. Энэхүү Дээд боловсролын сургалтын байгууллагад тавих техникийн зохицуулалтын дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох дүгнэлт гаргах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, дүгнэлт боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажилласан. Ажлын хэсэг дээд сургууль, коллежийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 32, шинээр сургууль байгуулах ангилал тогтоох хүсэлт гаргасан 3 буюу нийт 35 дээд боловсролын сургалтын байгууллагын ангиллыг тогтоох дүгнэлтийг гаргасан. Ажиллах явцдаа техникийн зохицуулалтын 2.1.4 -д заасан орчны стандарт, шаардлагуудад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зориулсан налуу шат, суултуур, тусгай тоног төхөөрөмжтэй эсэхтэй танилцаж, хяналт тавьсан. Мөн Боловсролын сайдын 2024 оны “Магадлан шалгах ажлын хэсэг байгуулах тухай” А/127 дугаар тушаалаар Зөвшөөрлийн цахим системээр дамжуулан Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 6.2, 6.5-д заасан энгийн болон тусгай зөвшөөрөл авахаар ирүүлсэн хүсэлтийн дагуу мэдээлэлтэй танилцаж, зарим тохиолдолд газар дээр нь баталгаажуулалт хийсэн. Энгийн зөвшөөрлийн 29, тусгай зөвшөөрлийн 3 хүсэлт ирсэнд өөрийн ажлын байрны чиг үүргийн дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны “ Нийтлэг шаардлага шинэчлэн батлах тухай” А/147 дугаар тушаалаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-ын 2.7-д заасан “Сургалтын орчны шаардлага”-ын хэрэгжилтэд магадлан шалгах ажлыг хийж, дүгнэлт гаргасан. Дээрх 35 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дээд боловсролын байгууллагын 91.4 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад үйлчилгээ үзүүлэх орчны нөхцөлийг өөрийн нөөц боломжид тулгуурлан шийдсэн байна. 2024-2025 оны хичээлийн жилд Их, дээд сургууль, коллежид нийт 150,282 суралцагч суралцаж байгаа бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй 436 суралцагч байгаа нь 0.3 хувийг эзэлж байна.<br>Хавсралт: 2 файл | | |
| 1.4. | Ерөнхий боловсролын сургуулийн 3 дугаар ангиас эхлэн англи хэл, кодчилол, роботик болон хиймэл оюуны ур чадварыг хөгжүүлэх сургалтыг нэвтрүүлнэ. Бүх түвшинд англи хэлний сургалтын чанарыг сайжруулж, ахлах сургууль, мэргэжлийн болон | - | - | - | - | | Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн "Нийтлэг шаардлага шинэчлэн батлах тухай" А/147 дугаар тушаалаар батлагдсан "Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага"-д дээд боловсролын ерөнхий суурь хэсгийн суралцахуйн үр дүнгийн "Хүмүүнлэгийн ухааны" агуулгын чиглэлд - Англи хэл (бусад хэл)-ээр ахисан дунд түвшинд ярих, сонсох, унших, бичих, мэргэжлийн эх сурвалжийг ашиглах чиглэлийг 6+ багц цаг судлахаар журамд тусгасан. Үүний дагуу дээд | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | техникийн боловсрол, дээд боловсролын сургалтын байгууллагад зарим хичээлийг англи хэлээр заах боломжийг бүрдүүлнэ. | | | | | | боловсролын сургалтын байгууллагууд сургалтын хөтөлбөрөө тус нийлэг шаардлагад нийцүүлэн шинэчлэн баталж сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. МУИС, Эм Ай Ю ДС, СЭЗИС, АШУҮИС, ХУИС зэрэг сургуульд сургалтын хөтөлбөрийг бүрнээр нь англи хэл дээр хэрэгжүүлж эхлээд байна.<br>Хавсралт: 2 файл | | |
| 1.4.1 | Дээд боловсролын сургалтын байгууллагын байгалийн ухааны хичээлийг англи хэлээр заах боломжийг бүрдүүлнэ. | - | Төрийн өмчийн их сургуулийн англи хэл дээр заах хичээлийн эзлэх хувь | 0.5 | 1 | 2 | Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн "Нийтлэг шаардлага шинэчлэн батлах тухай" А/147 дугаар тушаалаар батлагдсан "Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага"-д дээд боловсролын ерөнхий суурь хэсгийн суралцахуйн үр дүнгийн "Хүмүүнлэгийн ухааны" агуулгын чиглэлд - Англи хэл (бусад хэл)-ээр ахисан дунд түвшинд ярих, сонсох, унших, бичих, мэргэжлийн эх сурвалжийг ашиглах чиглэлийг 6+ багц цаг судлахаар журамд тусгасан. Үүний дагуу дээд боловсролын сургалтын байгууллагууд сургалтын | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөтөлбөрөө тус нийлэг шаардлагад нийцүүлэн шинэчлэн баталж сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. МУИС, Эм Ай Ю ДС, СЭЗИС, АШУҮИС, ХУИС зэрэг сургуульд сургалтын хөтөлбөрийг бүрнээр нь англи хэл дээр хэрэгжүүлж эхлээд байна. Дээд боловсролын газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 4/1414 тоот албан бичгээр сургуулиудад ахисан түвшний сургуулиуд нь сургалтын хөтөлбөрөө олон улсын сургуулиудын тэргүүлэх хөтөлбөрүүдтэй уялдуулан сургалтын бүтэц, зохион байгуулалтад сайжруулалт хийх, байгалийн ухааны хөтөлбөрийг англи хэл дээр хэрэгжүүлж, хөтөлбөрийн тоог нэмэгдүүлэх, нийт сургалтын хөтөлбөрийг англи хэл дээр заадаг болох чиглэл хүргүүлээд байна.<br>Хавсралт: 2 файл | | |
| 1.5. | Бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын | - | - | - | - | | “Оюутны дотуур байрны үйлчилгээ, ерөнхий шаардлага MNS 5869:2008” стандартыг шинэчлэн | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дотуур байрны хүртээмж, орчин, үйлчилгээний чанарыг сайжруулж, хүний эрхэд ээлтэй дотуур байрыг бий болгоно. | | | | | | батлуулахаар Стандарт хэмжил зүйн газарт хүргүүлсэн. Нийт дотуур байрны 15-20 хувь нь стандартын шаардлагыг хангаж байна.<br>Хавсралт: 4 файл | | |
| 1.5.1 | Дээд боловсролын сургалтын байгууллагын дотуур байрны стандартыг шинэчлэн батлуулж, стандартын шаардлага хангасан орчин бүрдүүлэх хөрөнгө оруулалтыг хийнэ. | 200.00 | Стандартын шаардлага хангасан дотуур байрны эзлэх хувь | 5 | 6 | 6 | Боловсролын сайдын "Ажлын хэсэг батлах тухай" 2024 оны А/149 дүгээр тушаалаар Дээд боловсролын сургалтын байгууллагын “Оюутны дотуур байрны үйлчилгээ, ерөнхий шаардлага”-ын стандартыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн дээд боловсролын байгууллагуудаас "Мэдээлэл ирүүлэх тухай" 4-845 тоот албан бичгээр судалгааг авч, нэгтгэсэн. Ажлын хэсэгт Эрүүл мэндийн яам, стандарт хэмжил зүйн газар, их, дээд сургуулийн хөрөнгийн менежментийн төв, оюутны холбоо, их сургуулиудын оюутны хөгжил хариуцсан албаны ажилтан, дотуур байрны багш, албан хаагчдыг оролцоог хангаж ажилласан. Оюутны дотуур байрны мөрдөгдөж байгаа | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | стандарт, шинээр батлагдсан бусад стандартууд, 2019 оны Оюутны дотуур байрны стандарт нөхцөл байдалд хийсэн эрсдэлийн үнэлгээний тайлан, эрүүл ахуйн хяналтын хуудас, сургуулиудаас ирүүлсэн санал, судалгаа зэргийг үндэслэн стандартын төслийн саналыг боловсруулсан.<br>Боловсролын сайдын 2024 оны 1/2452 тоот албан бичгээр “Оюутны дотуур байрны үйлчилгээ, ерөнхий шаардлага MNS 5869:2008” стандартыг шинэчлэн батлуулахаар Стандарт хэмжил зүйн газарт хүргүүлсэн. Стандартыг батлах хугацаа дунджаар 18 сар үргэлжилдэг бөгөөд одоогоор Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын газрын мэргэжилтэн Э.Анхзултай хамтран ажиллаж байна. Одоогийн байдлаар төрийн болон хувийн өмчийн дээд боловсролын байгууллагад нийт 69 дотуур байр суралцагчдад үйлчилгээ үзүүлж байна. Эдгээрийн 70 гаруй хувь нь 1999 оноос өмнө ашиглалтад орсон байгууламж бөгөөд одоогийн мөрдөж байгаа | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | стандартыг шаардлагыг 15-20 хувь нь хангаж байна. .2025 оны төсвийн хөрөнгө оруулалтаар дээд боловсролын салбарт шинэ, шилжих нийлсэн 88 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна. МУИС-ийн Ховд аймаг дахь салбар сургууль улсын төсвийн хөрөнгөөр 230 оюутны дотуур байр барих ажлыг Чандмань хангай ХХК-тай гэрээ байгуулан суурийг эхлүүлээд байна. Барилга 5 давхар бөгөөд нийт санхүүжилт 12,5 тэрбум төгрөг, 2027 онд дуусгах төлөвлөгдсөн.<br>Хавсралт: 4 файл | | |
| 1.6. | Төрийн өмчийн зарим их сургууль, политехник коллежийг түшиглэн техникийн болон дээд боловсролын шаталсан тогтолцоо бүхий сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолбор | - | - | - | - | | Дорнод, Орхон, Өмнөговь зэрэг 3 байршилд Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолборуудын ТЭЗҮ, ерөнхий төлөвлөгөө хийгдсэн.<br>Хавсралт: 4 файл | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | их сургууль, төрөлжсөн коллежийг бүсүүдэд хотхон хэлбэрээр хөгжүүлнэ. | | | | | | | | |
| 1.6.1 | Дээд боловсролын сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолбор, хотхоныг төрөлжүүлэн хөгжүүлнэ. | 1,602.00 | ТЭЗҮ батлагдсан “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолборын тоо | - | 0 | 2 | Төрийн өмчийн зарим их сургууль, политехник коллежийг түшиглэн техникийн болон дээд боловсролын шаталсан тогтолцоо бүхий сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолбор их сургууль, төрөлжсөн коллежийг бүсүүдэд хотхон хэлбэрээр хөгжүүлэх ажлыг үе шаттайгаар төлөвлөн ажиллаж байна. 1.Дархан-Уул аймагт бүтээн байгуулах “Сургалт- эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” төслийн ТЭЗҮ, Ерөнхий төлөвлөгөөний ажлын даалгавар боловсруулж батлуулсан. 2.Өмнөговь аймагт бүтээн байгуулах “Сургалт- эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” төслийн ТЭЗҮ, Ерөнхий төлөвлөгөө, эхний ээлжийн барилгажилтын хөрөнгө оруулалтыг Оюутолгой ХХК санхүүжүүлж байна. 3.Орхон бүтээн байгуулах “Сургалт- эрдэм | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” төслийн ТЭЗҮ, Ерөнхий төлөвлөгөө, эхний ээлжийн барилгажилтын хөрөнгө оруулалтыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ санхүүжүүлж байна. 4.“Хүннү” хотод бүтээн байгуулах “Сургалт- эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” төслийн ШУТИС-ийн харъяа Олон улсын сургуулийн инженерийн сургуулийн санамж бичиг, гэрээ зурагдсан. Концепц боловсруулан танилцуулагдаж байна. 5.Дорнод аймагт бүтээн байгуулах “Сургалт- эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” төслийн ТЭЗҮ, Ерөнхий төлөвлөгөө батлагдсан, хөрөнгө оруулалтын боломжууд судлагдаж байна. 6.Ховд аймаг дахь "Сургалт- эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор"-ын төслийн инженер геологийн суурь судалгаа 2012 онд хийгдсэн. Мөн төслийн техник, эдийн засгийн үндэслэл, ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаврын төслийг боловсруулж байна. 7.Багануурт байгуулах их сургуулийн хотхоны ТЭЗҮ, | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ерөнхий төлөвлөгөө, инженерийн дэд бүтэц, цахилгаан, дулаан хангамжийн зураг төсөл хийгдсэн. 2011 оны 367-р тогтоолоор “Их сургуулиудын хотхон”-ыг Багануур дүүргийн 4, 5 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх Хүрмэнтийн хөндийд байгуулна” гэж шийдвэрлэснийг үндэслэж, Багануур дүүрэгт 10000 га газар олгогдсон. Одоогийн байдлаар Дорнод, Орхон, Өмнөговь дахь Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолборуудын ТЭЗҮ, ерөнхий төлөвлөгөө хийгдсэн.<br>Хавсралт: 4 файл | | |
| 1.7. | Дээд боловсролын сургалтын байгууллагын элсэлтийн хувийг эрэлттэй нийцүүлж, элсэлтийн шалгалтын босго оноог нэмэгдүүлж, элсэгчийн чанарыг сайжруулна. | - | - | - | - | | Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" А/69 дугаар тушаалаар "элсэлтийн шалгалт зохион байгуулах журам"-д нэмэлт өөрчлөлт оруулсан. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 66 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Боловсролын сайдын 2024 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | А/130 дугаар тушаалаар ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн саналд үндэслэн Боловсролын сайдын 2024 оны 12 дугаар сарын 05-ны "Босго оноо тогтоох тухай" А/228 дугаар тушаалаар Дээд боловсролын сургалтын байгууллагын элсэлтийн хувийг эрэлттэй нийцүүлэн элсэлтийн шалгалтын босго оноог 10 оноогоор нэмэгдүүлэн тогтоосон.<br>Хавсралт: 3 файл | | |
| 1.7.1 | Дээд боловсролын сургалтын байгууллагын элсэлтийн шалгалтын эрх зүйн орчныг шинэчилнэ. | - | Ерөнхий боловсролын сургууль төгсөгчөөс их, дээд сургуульд элссэн суралцагчийн эзлэх хувь | 96 | 95 | 95 | Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" А/69 дугаар тушаалаар "элсэлтийн шалгалт зохион байгуулах журам"-д нэмэлт өөрчлөлт оруулсан. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 66 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Боловсролын сайдын 2024 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/130 дугаар тушаалаар ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн саналд үндэслэн Боловсролын сайдын 2024 оны 12 дугаар сарын 05-ны "Босго оноо тогтоох тухай" А/228 дугаар | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тушаалаар Дээд боловсролын сургалтын байгууллагын элсэлтийн хувийг эрэлттэй нийцүүлэн элсэлтийн шалгалтын босго оноог 10 оноогоор нэмэгдүүлэн тогтоосон. Босго онооны тушаалд үндэслэн дээд боловсролын сургалтын байгууллагууд элсэлтийн журмаа шинэчлэн боловсруулан элсэлтийн шалгалтын дараагаар элсэлтээ зохион байгуулах бэлтгэлийг хангасан. Боловсролын үнэлгээний төвөөс элсэлтийн шалгалтын товыг 2025 оны 6 дугаар сарын 18-21-ний өдрүүдэд зохион байгуулахаар төлөвлөсөн. 2024-2025 оны хичээлийн жилийн өвлийн элсэлтээр 2813 суралцагч шинээр элссэн байна.<br>Хавсралт: 3 файл | | |
| 1.8. | Эдийн засгийн тэргүүлэх чиглэл, орон нутгийн хөгжлийн зорилттой уялдуулан мэргэжлийн болон техникийн | - | - | - | - | | 1. Ажлын байранд суурилсан сургалт арга хэмжээний хүрээнд 2024-2025 оны хичээлийн жилд нийт дээд боловсролын 8 сургуульд 35 хөтөлбөр /давхардсан тоо/-өөр 389 оюутан суралцаж байна. 2. Боловсролын яамны ТНБД-ын 2025.04.14-ний өдрийн | 100% | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсрол, сургалтыг ажил олгогчийн шаардлага болон хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн, иргэдийг ажиллангаа суралцах, суралцангаа хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэн, хосмог ажлын байрны сургалтыг нэвтрүүлнэ. Эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн бэлтгэж байгаа их, дээд сургуулийн сургалтын чанарыг олон улсын жишигт нийцүүлнэ. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад | | | | | 2/1452 тоот албан бичгээр Монгол Улсаас Бүгд найрамдах Солонгос улсад суугаа элчин сайд С.Сүхболдод "Төслийн саналыг дэмжих бичиг" хүргүүлсэн. 2024-2025 онуудад Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлийн 37 хөтөлбөрүүдэд хөндлөнгийн үнэлгээ хийх шинжээчийн баг ажиллаж магадлан итгэмжлэлийн шийдвэр гарсан байна. Хавсралт: 4 файл | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллах эмч, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, сувилагчийг түлхүү бэлтгэнэ. | | | | | | | | |
| 1.8.1 | Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагч ажиллангаа сурах, суралцангаа ажиллах боломжийг бүрдүүлнэ. | 220.50 | Ажлын байранд суурилсан сургалтын хөтөлбөрийн тоо | 10 | 11 | 13 | Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагч оюутнууд сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу ахлах курст танилцах болон үйлдвэрлэлийн дадлага хийх хугацаандаа ажлын байран дээр дадлага хийж сургалтын багц цагийг цуглуулж мэргэжлийн хичээлээр олсон мэдлэгээ баталгаажуулдаг зохицуулалттай байсан. Улмаар БШУ-ны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн "Нийтлэг шаардлага шинэчлэн батлах тухай" 147 дугаар тушаалаар "Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага"-ыг шинэчлэн батласнаар оюутнууд суралцангаа сонгосон мэргэжлийн дагуу ажиллаж, мэдлэг чадвараа эзэмших эрх зүйн орчин бүрдсэн. Тус журмын 2.5.5.2-т "хөтөлбөрийн онцлогоос хамаарч дэд | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бакалавр, бакалаврын сургалтын төлөвлөгөөний дадлагыг ажлын байранд суурилсан сургалтын хэлбэрээр 20 хүртэл багц цагаар төлөвлөж болно", 2.5.5.3-т "сургууль ажлын байранд суурилсан дадлагын үйл ажиллагааг хөтөлбөрт тусгасан тохиолдолд зохион байгуулах хөтөлбөр боловсруулж мөрдөнө" гэж зохицуулсан нь оюутны суралцах хугацаандаа ажиллах, ажиллангаа суралцах боломжийг нээж өгсөн. Ажлын байранд суурилсан сургалт арга хэмжээний хүрээнд 2024-2025 оны хичээлийн жилд нийт 35 хөтөлбөр /давхардсан тоо/-оор 389 оюутан суралцаж байна. Тус хөтөлбөрүүдээр суралцагч оюутнууд ажлын цагийн онцлогоос хамаарч 650,000 төгрөгөөс 2,200,000 төгрөгийн цалинтайгаар суралцангаа ажиллаж байна.<br>Хавсралт: 3 файл | | |
| 1.8.2 | Эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн | - | 1. Тэргүүлэх мэргэжлээр магадлан итгэмжлэгдсэн | 1. 61 2. 1488 | 1. 190 2. 1700 | - | 1.Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.11-д анагаах ухааны мэргэжлийн чиглэлийн сургалтын хөтөлбөрийг | 100% | 90% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бэлтгэж байгаа их, дээд сургуулийн сургалтын чанарыг олон улсын жишигт нийцүүлнэ. | | хөтөлбөрөөр суралцсан төгсөгч, тоогоор /тухайн жилээр/ 2. Эрэлттэй мэргэжлээр магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрөөр төгсөгч, тоогоор /тухайн жилээр/ | | | | заавал магадлан итгэмжилнэ гэж заасан. Энэ хүрээнд Чанарын баталгаажуулалт-магадлан итгэмжлэлийн байгууллагаас анагаахын эрүүл мэндийн чиглэлийн сургалтын хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор “АНАГААХ УХААН, ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨТӨЛБӨРИЙГ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ НЭМЭЛТ ШААРДЛАГА” боловсруулсан. Уг шаардлагын дагуу 2024-2025 онд анагаах ухаан, нийгмийн хамгааллын чиглэлийн 37 хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийх шинжээчийн баг ажиллаж магадлан итгэмжлэлийн шийдвэр гаргасан байна. Анагаах, нийгмийн хамгааллын мэргэжлийн чиглэл, хөтөлбөрөөр 2024-2025 оны хичээлийн жилд дээд боловсролын сургалтын 30 байгууллагад 28316 оюутан суралцаж байна. 2.Боловсролын яам, АШУҮИС Солонгос улсад 1000 эрүүл мэндийн мэргэжилтэн бэлтгэх төсөл боловсруулан ажиллаж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын дэмжлэгтэйгээр төслийн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | саналыг БНСУ-д суугаа Элчин сайдад 2025 оны 04 дүгээр сарын 14-нд хүргүүлсэн. 3.Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль 2025 онд ROUND University Ranking (RUR) байгууллагын шалгуурыг хангаж, 2025 оны дэлхийн их сургуулиудын чансаанд Монгол Улсаас хамгийн өндөр байр эзэлсэн. Хавсралт: 3 файл | | |
| 1.9. | Төрийн өмчийн их сургуулиудыг сургалтын их сургуулиас судалгааны их сургууль болгон хөгжүүлж, академик эрх чөлөөг ханган, инновацын экосистемийг бүрдүүлнэ. | - | - | - | - | | 1. Засгийн газрын 2022 оны 409 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийг тогтоож, санхүүжүүлэх журам"-ын дагуу Монгол Улсын тэргүүн шадар сайд бөгөөд эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны “Судалгааны үндсэн чиглэлийг 2025 онд санхүүжүүлэх зардал батлах тухай” А/66 дугаар тушаалаар ШУТИС-ийн харьяа 5, МУИС-ийн харьяа 4 хүрээлэнд болон СУИС-ийн харьяа Соёл урлаг судлалын хүрээлэнд нийт 174.472.00 төгрөгийн санхүүжилт олгохоор гэрээ | 100% | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулж байна. Их сургуулиудын эрдэм шинжилгээ, судалгаа, инновацын үйл ажиллагаанд Боловсролын сайдын 2025 оны 05 дугаар сарын 1-ний өдрийн “Санхүүжилт олгох тухай” А/242 дугаар тушаалаар 338.000,00 төгрөгийг олгож, судалгааны ажил хийгдэж байна. 2. Инженер технологийн дээд боловсрол” төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дээд боловсролын сургалтын байгууллагад хийгдсэн судалгаа, эрдэм шинжилгээний ажлын үр дүнд нийт 1042 өгүүлэл хэвлэгдсэнээс гадаадад - 570, дотоодод-472 байна. Олон Улсын түшинд хүлээн зөвшөөрөгдсөн Web of Science, Scopus, JCR платформд бүртгэлтэй сэтгүүлд 340 гаруй өгүүлэл хэвлүүлж, 46 оюуны өмч, 3 шинэ бүтээгдэхүүнийг бүртгүүлж, 36 ашигтай загварын гэрчилгээ, 28 патентыг авсан байна. Хамтарсан судалгааны багийн судалгааны ажлын үр дүнд байгуулагдсан 5 гараана компани үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна. Тус төслийн санхүүжилтээр Япон Улсад | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | суралцаж төгссөн зарим докторууд өөрсдийн судалгааны сэдвийн хүрээнд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй 14 МЕГА төслийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж эхлээд байгаа бөгөөд цаашид энэхүү үйл ажиллагаа улам бүр өргөжин тэлэх нөхцөл бүрдээд байна. 3. Боловсролын сайдын 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн “Тушаалын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” А/220 дугаар тушаалаар Засгийн газрын шийдвэрээр шинээр байгуулагдсан их сургуулийн харьяаны хүрээлэнгүүдийн үйл ажиллагаанд 1.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгон ажиллана. 4. Дээд боловсролын сургалтын байгууллагын үндэсний эрэмбэ, чансаа, хөтөлбөрийн чанарыг тогтоох арга<br>Хавсралт: 6 файл | | |
| 1.9.2 | Төрийн өмчийн их сургуулиуд, харьяа хүрээлэнгүүдийн эрдэм | 800.00, 192.50, 950.00 | 1.Эрдэм шинжилгээ, инновацыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэ | 7, 450, 6 | 2, 470, 5 | 10, 505, 10 | 1. Засгийн газрын 2022 оны 409 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шинжилгээ, судалгаа, инновацын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлж, дэмжлэг үзүүлж ажиллана. | | н арга хэмжээ, 2.Төрийн өмчийн их сургуулийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний бүтээлийн тоо, 3.Санхүүжилт олгосон их сургуулийн харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгийн тоо | | | | чиглэлийг тогтоож, санхүүжүүлэх журам"-ын дагуу Монгол Улсын тэргүүн шадар сайд бөгөөд эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны “Судалгааны үндсэн чиглэлийг 2025 онд санхүүжүүлэх зардал батлах тухай” А/66 дугаар тушаалаар ШУТИС-ийн харьяа 5, МУИС-ийн харьяа 4 хүрээлэнд болон СУИС-ийн харьяа Соёл урлаг судлалын хүрээлэнд нийт 174.472.00 төгрөгийн санхүүжилт олгохоор гэрээ байгуулж байна. Их сургуулиудын эрдэм шинжилгээ, судалгаа, инновацын үйл ажиллагаанд Боловсролын сайдын 2025 оны 05 дугаар сарын 1-ний өдрийн “Санхүүжилт олгох тухай” А/242 дугаар тушаалаар 338.000,00 төгрөгийг олгож, судалгааны ажил хийгдэж байна. 2. Инженер технологийн дээд боловсрол” төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дээд боловсролын сургалтын байгууллагад хийгдсэн судалгаа, эрдэм шинжилгээний ажлын үр дүнд нийт 1042 өгүүлэл хэвлэгдсэнээс гадаадад -570, дотоодод-472 байна. | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Олон Улсын түшинд хүлээн зөвшөөрөгдсөн Web of Science, Scopus, JCR платформд бүртгэлтэй сэтгүүлд 340 гаруй өгүүлэл хэвлүүлж, 46 оюуны өмч, 3 шинэ бүтээгдэхүүнийг бүртгүүлж, 36 ашигтай загварын гэрчилгээ, 28 патентыг авсан байна. Хамтарсан судалгааны багийн судалгааны ажлын үр дүнд байгуулагдсан 5 гарааны компани үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна. Тус төслийн санхүүжилтээр Япон Улсад суралцаж төгссөн зарим докторууд өөрсдийн судалгааны сэдвийн хүрээнд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй 14 МЕГА төслийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж эхлээд байгаа бөгөөд цаашид энэхүү үйл ажиллагаа улам бүр өргөжин тэлэх нөхцөл бүрдээд байна. 3. Боловсролын сайдын 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн “Тушаалын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” А/220 дугаар тушаалаар Засгийн газрын шийдвэрээр шинээр байгуулагдсан их сургуулийн харьяаны хүрээлэнгүүдийн үйл | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажиллагаанд 1.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгон ажиллана.<br>Хавсралт: 3 файл | | |
| 1.9.3 | Дээд боловсролын сургалтын байгууллагын үндэсний эрэмбэ тогтоох арга хэмжээг зохион байгуулна. | 750.00 | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 5 | 25 | 50 | 1.Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.9-д Дээд боловсролын сургалтын байгууллагын үндэсний эрэмбэ, чансаа, хөтөлбөрийн чанарыг цахим сангийн мэдээлэлд үндэслэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний байгууллагатай хамтран 2 жил тутам тогтоон олон нийтэд мэдээлнэ гэж хуульчилсан арга хэмжээг зохион байгуулах бодлого төлөвлөлтийн талаар дээд боловсролын сургалтын байгууллагуудын удирдлагуудтай 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулж, санал авсан. Боловсролын яам, Боловсролын үнэлгээний төв, Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн холбогдох албаны төлөөллийн уулзалт хэлэлцүүлгийн 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулсан. Боловсролын яамны | 100% | 90% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн Чиглэл хүргүүлэх тухай 2/1610 тоот албан бичгээр Боловсролын ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.13-д заасны дагуу магадлан итгэмжлэх, чанарын баталгаажуулалтыг удирдлага, арга зүйгээр хангах, чиг үүргийнхээ хүрээнд дээд боловсролын сургалтын байгууллагын эрэмбэ тогтоох, сургалтын хөтөлбөрийн чанарын үнэлгээ хийх ажлыг олон улсын мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж ажиллах тухай чиглэлийг Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлд хүргүүлсэн. 2.Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/343 дугаар тушаалаар баталсан зардлыг хүрээнд Times Higher Education олон улсын байгууллагаас зөвлөх үйлчилгээ авч Монгол Улсын их сургуулийн дэлхийн их сургуулийн эрэмбийн суурь болзлыг хангахаар оруулсан үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдэд хийсэн дүн шинжилгээг | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2025 оны 02 дугаар сарын 21-ны өдөр онлайнаар танилцуулсан. 3.“Их сургуулиудын олон улсын эрэмбэ, докторын дараах хөтөлбөр: Туршлага, хамтын ажиллагаа” сэдэвт хэлэлцүүлгийг 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр төрийн өмчит зургаан их сургуультай хамтран зохион байгуулсан. Хавсралт: 3 файл | | |
| 1.10. | "Ерөнхийлөгчийн илгээлт 2100" тэтгэлэгт хөтөлбөрийг үргэлжлүүлнэ. | - | - | - | - | | 1.Монгол Улсын Засгийн газрын 215 дугаар тогтоолын хавсралтаар "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээлийг эргэн төлүүлэх журам"-ыг батлуулсан. Тус журамд 4.1-д "Монгол хүн бүрийг чанартай боловсрол эзэмших тэгш боломжоор бүрэн хангаж, орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах, эх оронч сэтгэлтэй, зөв хандлагатай, олон улсад өрсөлдөх мэдлэг, чадвартай, бүтээлч, манлайлагч иргэнийг бэлтгэх зорилгоор тухайн жилийн сонгон шалгаруулалтад тэнцсэн 500 хүртэлх суралцагчид | 100% | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлэг олгоно" мөн журмын 4.3-д тавигдах шаардлагыг "4.3.1.сүүлийн 3-аас доошгүй жил ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойргийн дагуу харьяалагдах сум, хороондоо суралцаж төгссөн байх, ахлах сургуульгүй сумын суралцагч бол харьяалагдах аймгийн аль нэг ердийн сургалттай сургуульд тасралтгүй 3-аас доошгүй жил суралцсан байх; 4.3.2.тухайн жилийн элсэлтийн шалгалтын "гадаад хэл-математик", "гадаад хэл-физик", "гадаад хэл-хими", "гадаад хэл-биологи" гэсэн хувилбарын хэмжээст онооны дунджаар 550, түүнээс дээш оноо авсан байх; 4.3.3.энэ журмын 4.3.2-т заасан хэмжээст онооны дунджаар хамгийн өндөр оноо авч, сум, хороондоо тэргүүлсэн байх." гэж туссан. 2.Боловсролын сайдын 2025 оны "Хяналтын тоо батлах тухай" А/127 дугаар тушаалыг батлан гаргасан. Тус тушаалын хавсралтад хамрагдах иргэний хяналтын тоог 330 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | суралцагч, төсвийг 1.2 тэрбум төгрөг байхаар туссан. Шинээр тус хөтөлбөрт хамрагдах суралцагчид 2025 оны 06 дугаар сарын 18-21-ний өдрүүдэд зохион байгуулагдах элсэлтийн шалгалтын дараа БҮТ-өөс сум, хороо бүрээс шалгарсан суралцагчдын мэдээллийн Боловсролын яаманд ирүүлж, батлуулан намар бэлтгэл хөтөлбөртөө хамрагдана.<br>3.Ерөнхийлөгчийн тэтгэлгийн бэлтгэл хөтөлбөрт 319 оюутан, гадаад улсуудад 758 нийт 1077 оюутан хамрагдан тэтгэлгээр суралцаж байна.<br>Хавсралт: 2 файл | | |
| 1.10.1 | "Ерөнхийлөгчийн илгээлт 2100" тэтгэлэгт хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 37,733.00 | Тэтгэлэгт хамрагдсан суралцагчийн тоо | 2024 оны гүйцэтгэл | Тэтгэлэгт хөтөлбөрт 600 суралцагчийг хамруулсан байна. | Тэтгэлэгт хөтөлбөрт 600 суралцагчийг хамруулсан байна. | 1.Монгол Улсын Засгийн газрын 215 дугаар тогтоолын хавсралтаар "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээлийг эргэн төлүүлэх журам"-ыг батлуулсан. Тус журамд 4.1-д "Монгол хүн бүрийг чанартай боловсрол эзэмших тэгш боломжоор бүрэн хангаж, орон нутгийн хөгжилд хувь нэмэр | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | оруулах, эх оронч сэтгэлтэй, зөв хандлагатай, олон улсад өрсөлдөх мэдлэг, чадвартай, бүтээлч, манлайлагч иргэнийг бэлтгэх зорилгоор тухайн жилийн сонгон шалгаруулалтад тэнцсэн 500 хүртэлх суралцагчид Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлэг олгоно" мөн журмын 4.3-д тавигдах шаардлагыг "4.3.1.сүүлийн 3-аас доошгүй жил ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойргийн дагуу харьяалагдах сум, хороондоо суралцаж төгссөн байх, ахлах сургуульгүй сумын суралцагч бол харьяалагдах аймгийн аль нэг ердийн сургалттай сургуульд тасралтгүй 3-аас доошгүй жил суралцсан байх; 4.3.2.тухайн жилийн элсэлтийн шалгалтын "гадаад хэл-математик", "гадаад хэл-физик", "гадаад хэл-хими", "гадаад хэл-биологи" гэсэн хувилбарын хэмжээст онооны дунджаар 550, түүнээс дээш оноо авсан байх; 4.3.3.энэ журмын 4.3.2-т заасан хэмжээст онооны дунджаар хамгийн өндөр оноо авч, сум, | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хороондоо тэргүүлсэн байх." гэж туссан. 2.Боловсролын сайдын 2025 оны "Хяналтын тоо батлах тухай" А/127 дугаар тушаалыг батлан гаргасан. Тус тушаалын хавсралтад хамрагдах иргэний хяналтын тоог 330 суралцагч, төсвийг 1.2 тэрбум төгрөг байхаар туссан. Шинээр тус хөтөлбөрт хамрагдах суралцагчид 2025 оны 06 дугаар сарын 18-21-ний өдрүүдэд зохион байгуулагдах элсэлтийн шалгалтын дараа БҮТ-өөс сум, хороо бүрээс шалгарсан суралцагчдын мэдээллийн Боловсролын яаманд ирүүлж, батлуулан намар бэлтгэл хөтөлбөртөө хамрагдана.<br>3.Ерөнхийлөгчийн тэтгэлгийн бэлтгэл хөтөлбөрт 319 оюутан, гадаад улсуудад 758 нийт 1077 оюутан хамрагдан тэтгэлгээр суралцаж байна.<br>Хавсралт: 3 файл | | |
| 1.11. | Суралцагчдад олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөрөөр суралцах, | - | - | - | - | | Боловсролын яамны БНБТГ-ын даргаар ахлуулан Монгол Улсад төрөлжсөн ахлах сургууль байгуулах чиглэлээр дээд, мэргэжлийн болон | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дараагийн түвшний сургалтад кредит шилжүүлэн сурах, зарим мэргэжлийн дээд боловсролын сургалтын байгууллагыг 3 жилд төгсөх боломжийг олгох зорилгоор мэргэжлийн эрхтэй ахлах сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, технологийн коллеж, их сургуулийг төрөлжүүлэн хөгжүүлнэ. | | | | | | техникийн боловсролын сургалтын байгууллагын ректор, захирал, дээд боловсролын сургалтын байгууллагын харьяа ахлах сургуулийн захирал, эрдэмтэн, судлаач нартай уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлэг хийсэн. Боловсролын сайдын 2025 оны 05 "Чиглэл батлах тухай" А/188 тоот тушаалаар "Төрөлжсөн ахлах сургуулийн талаар баримтлах чиглэл"-ийг баталсан.<br>Хавсралт: 2 файл | | |
| 1.11.1 | Төрөлжсөн ахлах сургууль, политехник коллеж, коллеж, их сургуулийн шаталсан сургалтыг нэвтрүүлнэ. | - | Шаталсан сургалтад хамрагдсан суралцагчдын тоо | 1200 | - | 1300 | Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн "Нийтлэг шаардлага шинэчлэн батлах тухай" А/147 дугаар тушаалаар батлагдсан "Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага"-ыг шинэчлэн | 90% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | баталсан. Тус журмаар суралцан шатлан суралцах, өмнө суралцсан хөтөлбөр, хичээлийн агуулгаа дүйцүүлэн тооцуулах зохицуулалттай болсон. Үүний дагуу дээд боловсролын сургалтын байгууллагууд сургалтын хөтөлбөрөө тус нийлэг шаардлагад нийцүүлэн шинэчлэн баталж сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Техник боловсролын сургуульд техник мэргэжлийн боловсрол эзэмшсэн иргэд Дээд боловсролын тухай хууль, дээд боловсролын сургалтын байгууллагад элсүүлэх журамд заасны дагуу элсэлтийн ерөнхий шалгалтын оноо шаардахгүй элсүүлэн суралцуулах болом бүрдсэн. Боловсролын яамны БНБТГ-ын даргаар ахлуулан Монгол Улсад төрөлжсөн ахлах сургууль байгуулах чиглэлээр дээд, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын ректор, захирал, дээд боловсролын сургалтын байгууллагын харьяа ахлах сургуулийн захирал, эрдэмтэн, судлаач нартай уулзалт, хэлэлцүүлгийг | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зохион байгуулж, хэлэлцүүлэг хийсэн. Боловсролын сайдын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн "Чиглэл батлах тухай" А/188 тоот тушаалаар "Төрөлжсөн ахлах сургуулийн талаар баримтлах чиглэл"-ийг баталсан. Тус тушаалын 2.8-д "төрөлжсөн ахлах сургууль, их сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн мэргэжлийн чиглэлийн хөтөлбөр хэрэгжүүлэхэд хамтран ажиллахыг Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлагад" үүрэг болгон зохицуулсан. Техникийн боловсролоос дээд боловсроолд тухайн суралцсан чиглэлийн шагуу шатлан суралцах тогтолцоо бүрдсэн. Мөн Коллежоос их сургуульд шатлан суралцах боломжтой.<br>Хавсралт: 2 файл | | |
| 1.12. | Монгол Улсын их, дээд сургуулиуд | - | - | - | - | | 1. Дээд боловсролын газрын даргаас 2024 оны 10 дугаар сарын 07-ны | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дэлхийн шилдэг их сургуулиудтай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, гадаадын нэр хүнд бүхий судлаач, эрдэмтдийг урьж ажиллуулах, оюутнуудыг гадаад улсад зуны сургалтад хамруулах бодлого хэрэгжүүлнэ. | | | | | | өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 4/1414 тоот албан бичгээр байгалийн ухааны хөтөлбөрийг англи хэл дээр хэрэгжүүлж, хөтөлбөрийн тоог нэмэгдүүлэх чиглэл хүргүүлээд байна. 2024-2025 оны хичээлийн жилийн II улиралд ДБСБ-аас нийт 18 сургуулиас 115 хөтөлбөрийн хүрээнд хамтарсан хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Мөн гадаадаас англи хэлтэй профессорууд, гадаадын их, дээд сургуульд багшилдаг монгол багш нарыг урьж багшлуулж, сургуулийн нийт багш нарын 10 хүртэлх хувьд хүргэх чиглэл хүргүүлэв. 2024-2025 оны хичээлийн жилд дээд боловсролын 32 сургалтын байгууллагад гадаад улсаас хамтын ажиллагааны хүрээнд 147 эрдэмтэн багш ирж ажиллаж байна.<br>Хавсралт: 2 файл | | |
| 1.12.1 | Дэлхийн шилдэг их сургуулиудтай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 147.00 | Хамтарсан хөтөлбөрийн тоо | 5 | 6 | 7 | Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 6.2-т “дээд боловсролын шинэ мэргэжлээр сургалт явуулах”, 6.5-д “магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэх” энгийн зөвшөөрлийг тус тус | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Боловсролын яамнаас олгох зохицуулалттай. Энгийн зөвшөөрөл авсны үндсэн дээр Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/146 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-ын 2.5.8-д заасны дагуу хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх боломж бүрдсэн. Дээд боловсролын сургалтын байгууллагууд гадаадын өндөр хөгжилтэй орны дээд боловсролын сургалтын байгууллагатай хамтран ажиллах хүсэлтэд дээд боловсролын газраас дэмжлэг үзүүлж, хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих зорилтын хүрээнд газрын даргын 2024 оны "Чиглэл хүргүүлэх тухай" 4/1414 тоот албан бичгээр сургуулиудад ахисан түвшний сургуулиуд нь сургалтын хөтөлбөрөө олон улсын сургуулиудын тэргүүлэх хөтөлбөрүүдтэй уялдуулан сургалтын бүтэц, зохион байгуулалтад сайжруулалт хийх, байгалийн ухааны хөтөлбөрийг англи хэл дээр хэрэгжүүлж, хөтөлбөрийн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тоог нэмэгдүүлэх чиглэл хүргүүлсэн. Энэхүү бодлогын хүрээнд нийт 18 дээд боловсролын сургалтын байгууллага гадаадын шинжлэх ухаан өндөр хөгжсөн орны дээд боловсролын сургалтын байгууллагатай хамтарсан хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Хавсралт: 4 файл | | |
| 1.12.2 | Монгол Улсын их, дээд сургуулиудад гадаадын нэр хүнд бүхий судлаач, эрдэмтдийг урьж ажиллуулж, оюутнуудад зуны сургалтад хамрагдах боломжийг бий болгоно. | 2,100.00, 472.50 | 1.Зочин судлаач, эрдэмтдийн тоо, 2.Зуны сургалтад хамрагдсан оюутны тоо | 0, 0 | 3, 0 | 10, 50 | Дээд боловсролын сургалтын байгууллагууд гадаадын өндөр хөгжилтэй орны дээд боловсролын сургалтын байгууллага, дэлхийн шилдэг их, дээд сургуулийн эрдэмтэн багш, профессор нарыг монгол урьж ажиллахад дээд боловсролын газраас дэмжлэг үзүүлж, хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна. Дээд боловсролын газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 4/1414 тоот албан бичгээр "Гадаадаас англи хэлтэй профессорууд, гадаад их сургуульд монгол багш нарыг урьж багшлуулж, сургуулийн нийт багш нарын 10 хүртэлх хувьд | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүргэх" чиглэл хүргүүлсэн. Боловсрол, шинжлэх ухааны сайдын ын сайдын 2024 оны А/50 дугаар тушаалаар дээд боловсролын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээг баталгаажуулах ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсгийн хүрээнд чиг үүргийн дагуу гадаадын их сургуулиас Монголын улсын дээд боловсролын сургалтын байгууллагад ирж ажиллаж буй багш нарын мэдээллийг авч, хянаж ажиллахад дээд боловсролын 32 сургалтын байгууллагад гадаад улсаас хамтын ажиллагааны хүрээнд 147 эрдэмтэн багш ирж ажиллаж байна. Боловсролын яамны зүгээс дээд боловсролын сургалтын байгууллагад гадаадаас англи хэлтэй профессорууд ирж ажиллахад бодлогын дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Дээд боловсролын сургалтын байгууллагын оюутан суралцагчид мэргэжлийн дагуу богино хугацааны сургалт дадлагад энэ хичээлийн жилд МУИС-иас Япон улсад "ITGEL INTERNSHIP" | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөтөлбөрт 5 оюутан, МУБИС-иас БНХАУ, ОХУ, БНСУ, БНПУ, Япон улсын их сургуулиудад нийт 89 оюутан, СУИС-иас Япон, АНУ, ХБНГУ улсууд болон ERASMUS+ хөтөлбөрийн санхүүжилттэй төслийн хүрээнд нийт 43 оюутнууд хамрагдсан. Хавсралт: 4 файл | | |
| 1.13. | Дээд боловсролын салбарын хууль тогтоомжид заасан эрх зүйн актыг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангана. | - | - | - | - | | 1. "Мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсролын сургалтын байгууллага болон хөтөлбөрийг магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэл хийх журам болон шинжээчид тавих шаардлага"-ыг боловсруулсан. 2. Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн “Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/91 дүгээр тушаалыг баталж, докторын зэрэг хамгаалуулах дэд зөвлөлийн шаардлага хангасан 19 их сургуульд 4/874 дугаар албан тоотоор хүргүүлж ажилласан. Дээрх тушаалаар докторын зэрэг хамгаалуулах бүрэлдэхүүнээс гадна | 100% | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөвлөлийн чиглэл, хөтөлбөрийн жагсаалтыг шинэчлэн баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Докторын зэрэг хамгаалуулах 39 чиглэлд давхацсан тоогоор 761 эрдэмтэд багтсан байна. 3. Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж үзүүлэх, дэмжлэг олгох журамд Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2025 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 03 дугаар тогтоол, холбогдох яамдын саналыг тусган боловсруулж Засгийн газрын 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан. 4. Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индексийн сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрлийг шинэчилсэн.<br>Хавсралт: 8 файл | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.13.1 | "Мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсролын сургалтын байгууллага болон хөтөлбөрийг магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэл хийх журам болон шинжээчид тавих шаардлага"-ыг боловсруулан батлуулна. | - | Батлагдсан журам | Журмын төсөл 60 хувь | Журам, шаардлагын төсөл батлуулсан байна. | - | "Мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын сургалтын байгууллага болон хөтөлбөрийг магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэл хийх журам", "Мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын сургалтын байгууллага болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэл хийх шинжээчид тавих шаардлага"-ын төслийг тус тус боловсруулж, яамны цахим хуудсанд байршуулан олон нийтээс санал авч, шинэчлээд Боловсролын сайдын 2025 оны 1/1041 тоот албан бичгээр Монголын Хуульчдын холбоонд журам, шаардлагын төслийг хүргүүлж, ирүүлсэн саналын хүрээнд хэлэлцүүлэг яамны холбогдох газар, хэлтэс, БМИҮЗ-ийн төлөөллийг оролцуулан 2025.05.29-ний өдөр хэлэлцүүлэг зохион байгуулж, журам шаардлагын төслийг яамны албан хэрэг хөтлөлтийн систем /365/-д оруулан холбогдох нэгжийн дарга нарт танилцуулан | 90% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | санал авч байна. Журмыг 2025 оны 06 дугаар сарын эхний хагаст ТНБД-ийн дэргэдэх зөвлөлөөр хэлэлцүүлэх чиглэлийг Төрийн захиргаа, уидрдлагын газрын даргаас өгсөн болно. Мөн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тус хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.9 дэх заалтыг "Боловсролын сургалтын байгууллагын болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэх үйл ажиллагаа эрхлэх" зөвшөөрөл олгох гэж тусгагдсан тул Боловсролын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд холбогдох заалтын саналаа томьёолон ирүүлсэн.<br>Хавсралт: 4 файл | | |
| 1.13.2 | Докторын зэрэг хамгаалуулах зөвлөл, дээд боловсролын сургалтын байгууллагыг түшиглэн байгуулсан дэд зөвлөлийн үйл | - | Боловсролын сайдын тушаал | БШУ-ны сайдын 2024 оны А/52 дугаар тушаал | Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг батална. | Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн үйл ажиллагааг удирдлага зохицуулалтаар хангана. | Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны "Дүрэм шинэчлэн батлах тухай" А/575 дугаар тушаалаар батлагдсан "Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм"-ийн 1.7-д "Энэхүү дүрмийн 2.9-д заасан шаардлага хангасан дээд боловсролын сургалтын | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааг удирдлага зохицуулалтаар хангах | | | | | | байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны болон бусад байгууллагын эрдэмтдийн хүсэлтийг жил бүрийн 1 дүгээр сард нээлттэй, цахим хэлбэрээр хүлээн авч, Шинжлэх ухаан, технологийн сангийн мэдээллийн системд бүртгэнэ.” гэж заасны дагуу эрдэмтдийн бүртгэлийг цахимаар бүртгэх ажлыг зохион байгуулсан. Дээд боловсролын газрын даргын “Мэдээллийн системд бүртгүүлэх тухай” 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 4/2924 дүгээр албан бичиг болон Боловсролын яамны вэб сайтад бүртгэлийн зарыг байршуулан олон нийтийг нээлттэй, тэгш хүртээмжтэй мэдээллээр хангаж ажилласан.Бүртгэлийн системд 1158 эрдэмтэд хандаж, 859 хүн холбогдох дүрэмд заасан шаардлагын дагуу мэдээлэл болон нотлох баримтаа бүрэн гүйцэд оруулж амжилттай бүртгүүлж, оролцсон. Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн “Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | А/91 дүгээр тушаалыг баталж, докторын зэрэг хамгаалуулах дэд зөвлөлийн шаардлага хангасан 19 их сургуульд 4/874 дугаар албан тоотоор хүргүүлж ажилласан. Дээрх тушаалаар докторын зэрэг хамгаалуулах бүрэлдэхүүнээс гадна зөвлөлийн чиглэл, хөтөлбөрийн жагсаалтыг шинэчлэн баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Докторын зэрэг хамгаалуулах 39 чиглэлд давхацсан тоогоор 761 эрдэмтэд багтсан байна.<br>Хавсралт: 3 файл | | |
| 1.13.3 | Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журмыг | - | Батлагдсан журам | Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоол | Журмыг шинэчлэн батлуулна. | - | Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж үзүүлэх, дэмжлэг олгох журамд Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2025 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 03 дугаар тогтоол, холбогдох яамдын саналыг тусган боловсруулж Засгийн газрын 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шинэчлэн боловсруулан батлуулна. | | | | | | хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан. Хавсралт: 1 файл | | |
| 1.13.4 | Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индекстэй дүйцүүлсэн жагсаалтыг боловсруулж, зөвлөмж хүргүүлнэ. | Мэргэжлийн чиглэл, индекстэй дүйцүүлсэн жагсаалтыг боловсруулна. | Жагсаалт батлуулсан байна. | Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны “Мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индекс шинэчлэн батлах тухай” А/146, 2024 оны “Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/284 дүгээр тушаал | Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индекстэй дүйцүүлсэн жагсаалтыг боловсруулна. | Жагсаалтыг ашиглах зөвлөмж, гарын авлага боловсруулсан байна. | Боловсролын сайдын 2025 оны 01 дугаар сарын 06-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/02 дугаар тушаалаар "Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл/ хөтөлбөрийн нэр/, индекстэй дүйцүүлсэн жагсаалтын төсөл боловсруулах ажлын хэсэг"-ийг байгуулсан. Ажлын хэсгээс Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл/ хөтөлбөрийн нэр/, индекстэй дүйцүүлсэн жагсаалтын төслийн 2024 оноос урагш 1996 он хүртэл нийт төгсөгчийн эзэмшсэн хөтөлбөртэй дүйцүүлэх ажлыг 1996 оноос хойш 2024 оныг хүртэл 3,209 хөтөлбөрийн хүрээнд хийж дуусган нийт 65 дээд боловсролын сургалтын байгууллагад хүргүүлэн дүйцүүлсэн тус төсөлд санал авсан. Ажлын хэсгийн нарийн бичгийн зүгээс ажлын хэсгийн хурлыг 14 хоног тутам | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зохион байгуулж, бүх гишүүдийн санал, шүүмжийг тусган хэлэлцүүлж ажилласан. Хөтөлбөр дүйцүүлэх жагсаалтыг боловсруулан дээд боловсролын сургалтын байгууллагад хүргүүлэн саналыг авч нэгтгэн ажлын хэсэгт танилцуулж, хэлэлцүүлэн эцэслэж бэлэн болгов. Ажлын хэсгийн 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хурлаар гишүүдээс санал авч ажлын хэсгийн дүгнэлтийн дагуу 3 сургуулийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хавсралтыг шинэчлэн, бичилт хийж хүргүүлсэн Яамдаас ирүүлсэн саналын хүрээнд Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн "Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" А/287 дугаар тушаалаар "Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индексэд нэмэгдэх, хасагдах, өөрчлөгдөх" хөтөлбөрүүдийг шинэчлэн баталсан.<br>Хавсралт: 4 файл | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | | | |
| 3.1. | Багшийн мэргэжил дээшлүүлэх үндэсний тогтолцоог бэхжүүлэн, багшлах эрх олгох хялбаршуулсан сургалтын зохицуулалтыг бий болгож, багш бус мэргэжилтэй шилдэг боловсон хүчнийг багшаар бэлтгэх замаар хүний нөөцийн чадавхыг сайжруулж, багшийн хомсдолыг бууруулна. | - | - | - | - | | Боловсролын яамны 2024-2025 оны статистик мэдээлэлийн тоогоор 2024-2025 оны хичээлийн жилд дээд боловсролын сургалтын байгууллагад: Цэцэрлэгийн багш-3,989, бага ангийн багш-950, ерөнхий боловсролын сургуулийн багш-8,875, англи хэлний багш-367, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш-31 суралцагчийг бэлтгэж байна.<br>Хавсралт: 2 файл | 100% | 100 % |
| 3.1.1 | Багш мэргэжлээр суралцагчдад зээл, тэтгэлэг олгох замаар, багшийн хомсдолыг бууруулна. | - | Боловсролын зээлийн сангаар суралцагчийн тоо | 4834 | 4834 | 5000 | Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн “Мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индекс шинэчлэн батлах тухай” А/146 дугаар тушаалаар “ Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | /хөтөлбөрийн нэр/, индекс”-ийг шинэчлэн баталсан. Түүний дагуу дээд боловсролын сургалтын байгууллагаас цэцэрлэгийн багш, бага ангийн багш, ерөнхий боловсролын сургуулийн багш, англи хэлний багш, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багшийг дотоодод бэлтгэж байна. Үүний хүрээнд 2024-2025 оны хичээлийн жилд дээд боловсролын сургалтын байгууллагад: Цэцэрлэгийн багш-3,989, бага ангийн багш-950, ерөнхий боловсролын сургуулийн багш-8,875, англи хэлний багш-367, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш-31 суралцагчийг бэлтгэж байна. Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн "Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" А/287 дугаар тушаалаар "Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индексэд нэмэгдэх, хасагдах, өөрчлөгдөх" | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөтөлбөрүүдийг шинэчлэн баталсан.<br>Хавсралт: 3 файл | | |
| 3.2. | Багшийн хөдөлмөрийн бүтээмжийг бодитоор үнэлж, багш, ажилчдын цалин, хөдөлмөрийн хөлсний хэмжээг төсөв, мөнгөний бодлоготой уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлж, улсын дундаж хэмжээнд хүргэж, нийгмийн баталгааг хангана. | - | - | - | - | | Дээд боловсролын газрын Сургалтын хөтөлбөр, үнэлгээ, хүний нөөцийн бодлогын удирдлага, зохицуулалт хариуцсан шинжээчийн чиг үүргийн хувьд Багшийн орон сууцны судалгааг Боловсролын ерөнхий газрын Дээд боловсролын багшийн хөгжил хариуцсан арга зүйч, ахлах мэргэжилтэн Ж.Солонготой хамтран зохион байгуулж цахимаар авсан. 2025 оны 5 дугаар сараас эхлэн явуулсан судалгаанд нийт 13 сургуулийн 59 багш, ажилтан оролцсон байна. Үүнээс харахад дээд боловсролын сургалтын багшийн цалин 1,140,000-2,500,000 төгрөгийн хооронд байна. Орон сууцны судалгаагаар өөрийн орон сууцтай 31, эцэг эхийн хамтаар 9, түрээсийн орон сууцаар 11, өөрийн хашаа байшинд 7, түрээсийн хашаа байшинд 1 багш, ажилтан амьдардаг гэсэн байна.<br>Хавсралт: 1 файл | 100% | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.2 | Багшийн орон сууцны нөхцөлийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр дээд боловсролын сургалтын байгууллагын багш нарын орон сууцны судалгааг авч нэгтгэнэ. | - | Орон сууцны нөхцөлөө судалгаа | - | Судалгаа хийхэд удирдлага, зохицуулалтаар хангасан байна. | Судалгаа хийсэн байна. | Дээд боловсролын газрын Сургалтын хөтөлбөр, үнэлгээ, хүний нөөцийн бодлогын удирдлага, зохицуулалт хариуцсан шинжээчийн чиг үүргийн хувьд Багшийн орон сууцны судалгааг Боловсролын ерөнхий газрын Дээд боловсролын багшийн хөгжил хариуцсан арга зүйч, ахлах мэргэжилтэн Ж.Солонготой хамтран зохион байгуулж цахимаар авсан. 2025 оны 5 дугаар сараас эхлэн явуулсан судалгаанд нийт 13 сургуулийн 59 багш, ажилтан оролцсон байна. Үүнээс харахад дээд боловсролын сургалтын багшийн цалин 1,140,000-2,500,000 төгрөгийн хооронд байна. Орон сууцны судалгаагаар өөрийн орон сууцтай 31, эцэг эхийн хамтаар 9, түрээсийн орон сууцаар 11, өөрийн хашаа байшинд 7, түрээсийн хашаа байшинд 1 багш, ажилтан амьдардаг гэсэн байна.<br>Хавсралт: 1 файл | 100% | 100 % |
| 3.3. | Багшлах хүний нөөцийг чадавхжуулж, цэцэрлэгийн | - | - | - | - | | Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн “Мэргэжлийн чиглэл | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 10000 багш, бага ангийн 2000 багш, ерөнхий боловсролын сургуулийн 11000 багш, англи хэлний 2000 багш, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын 2000 багшийг гадаад, дотоодод бэлтгэнэ. | | | | | /хөтөлбөрийн нэр/, индекс шинэчлэн батлах тухай” А/146 дугаар тушаалаар “ Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индекс”-ийг шинэчлэн баталсан. Түүний дагуу дээд боловсролын сургалтын байгууллагаас цэцэрлэгийн багш, бага ангийн багш, ерөнхий боловсролын сургуулийн багш, англи хэлний багш, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багшийг дотоодод бэлтгэж байна. Үүний хүрээнд 2024-2025 оны хичээлийн жилд дээд боловсролын сургалтын байгууллагад: Цэцэрлэгийн багш-3,989, бага ангийн багш-950, ерөнхий боловсролын сургуулийн багш-8,875, англи хэлний багш-367, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш-31 суралцагчийг бэлтгэж байна. Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн "Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" А/287 дугаар тушаалаар "Дээд боловсролын | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индексэд нэмэгдэх, хасагдах, өөрчлөгдөх" хөтөлбөрүүдийг шинэчлэн баталсан. Хавсралт: 3 файл | | |
| 3.3.1 | Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын багш бэлтгэх их, дээд сургуулийн багшийг гадаад, дотоодод бэлтгэж, мэргэшүүлнэ. | 560.00 | Гадаад, дотоодод мэргэшүүлэх сургалтад хамрагдсан багш бэлтгэдэг дээд боловсролын сургалтын байгууллагын багшийн тоо | - | 2 | 20 | Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн “Мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индекс шинэчлэн батлах тухай” А/146 дугаар тушаалаар “ Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индекс”-ийг шинэчлэн баталсан. Түүний дагуу дээд боловсролын сургалтын байгууллагаас цэцэрлэгийн багш, бага ангийн багш, ерөнхий боловсролын сургуулийн багш, англи хэлний багш, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багшийг дотоодод бэлтгэж байна. Үүний хүрээнд 2024-2025 оны хичээлийн жилд дээд боловсролын сургалтын байгууллагад: Цэцэрлэгийн багш-3,989, бага ангийн багш-950, ерөнхий | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | боловсролын сургуулийн багш-8,875, англи хэлний багш-367, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш-31 суралцагчийг бэлтгэж байна. Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн "Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" А/287 дугаар тушаалаар "Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индексэд нэмэгдэх, хасагдах, өөрчлөгдөх" хөтөлбөрүүдийг шинэчлэн баталсан.<br>Хавсралт: 3 файл | | |
| 3.3.2 | Бага ангийн 2,000 багш, ерөнхий боловсролын сургуулийн 11,000 багш (тусгай хэрэгцээт боловсролын багшийг оруулаад), англи хэлний 2,000 багшийг гадаад, дотоодын их, | 285.00 | Бага ангийн багшаар бэлтгэгдэж, мэргэшсэн багшийн тоо, Ерөнхий боловсролын багш (тусгай хэрэгцээт боловсролын багш орно)-аар бэлтгэгдэж, мэргэшсэн | 5413, 1501, - | - | 1,000, 400, 500 | 1. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-ыг шинэчлэн Монгол Улсын Засгийн газрын 215 дугаар тогтоолын хавсралтаар "Дээд боловсролын | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дээд сургууль, коллежид бэлтгэж, мэргэшүүлнэ. | | багшийн тоо , Англи хэлний багшаар бэлтгэгдэж, мэргэшсэн багшийн тоо | | | | сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээлийг эргэн төлүүлэх журам"-ыг батлуулсан. Тус журамд 5.4-д "Төрийн албан хаагчийн магистрын зэргийн өмнөх хэлний бэлтгэл, ахисан түвшний сургалтад суралцах албан хаагч энэ журмын 2.2-т заасан нийтлэг шаардлага болон дараах тусгай шаардлага хангасан байна: 5.4.1.төрийн албанд 5-аас доошгүй жил, тухайн байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан үндсэн ажилтан байх; 5.4.2.төрийн албан хаагчийн хувьд сүүлийн 3 жилийн гүйцэтгэлийн үнэлгээгээр холбогдох журамд заасан хамгийн өндөр үнэлгээний ангилалд багтсан байх; 5.4.3.ажиллаж буй байгууллага захиалга өгсөн байх; 5.4.4.гадаадын сургалтын байгууллагад суралцан төгсөж ирээд 5 жил ажиллах боломжтой байх (өндөр насны болон цэргийн тэтгэвэр тогтоолгох насны хязгаар, төрийн тусгай албаны 20-25 жил ажилласан байх нөхцөлөөс үлдсэн хугацаа | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 10 жилээс доошгүй байх)" гэж туссан. 2.Боловсролын сайдын 2025 оны "Хяналтын тоо батлах тухай" А/127 дугаар тушаалыг батлан гаргасан. Тус тушаалын хавсралтад “1+2” буюу гадаадад хэлний болон ахисан түвшний сургалтад хамрагдах иргэний хяналтын тоог 26 байхаар туссан. 3.Боловсролын сайдын 2025 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/271 дугаар сонгон шалгаруулалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Шаардлага хангасан төрийн албан хаагчдын мэдээлэл ирэхэд сонгон шалгаруулна.<br>Хавсралт: 3 файл | | |
| 3.4. | Боловсрол сургалтын үйл ажиллагаанд хиймэл оюун ухаан, дэвшилтэт технологи нэвтрүүлж, багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан | - | - | - | - | | Боловсролын сайдын 2025 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/55 дугаар тушаалын хавсралтаар "Судалгааны ажлын хуулбарлалтыг шалгах журам" батлагдсан. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 1/1711 тоот албан бичгээр тус журмыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянаад захиргааны хэм хэмжээний | 100% | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | контент, сургалтын сан, платформ, мэдээллийн технологийн хөтөлбөр, агуулгыг боловсруулж, хиймэл оюунд суурилсан цахим сурах бичгийг хөгжүүлж, хүүхэд бүрд цахим төхөөрөмж олгоно. | | | | | актын улсын нэгдсэн сангийн 7188 дугаарт бүртгэн ирүүлсэн. Дээд боловсролын сургалтын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллагын багш, судлаач , суралцагчийн эрдэм шинжилгээ, судалгааны ажил, бүтээлийн хуулбарлалтын хувь хэмжээг тогтоох, судалгааны ажлын нэгдсэн мэдээллийн санг бий болгох, түүнийг ашиглахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулна. Журмыг дээд боловсролын байгууллага, эрдэм шинжилгээний судлаач, багш суралцагч, Шинжлэх ухаан, технологийн сан, цахим дэд бүтэц хариуцагч дагаж мөрдөнө. Шинжлэх ухаан, технологийн сангийн мэдээллийн сангийн цахим хөгжүүлэлтийн хувь 15-20 хувьтай байна. Зөвшөөрлийн цахим систем бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд Боловсролын яамнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий дээд боловсролын сургалтын байгууллагын тусгай зөвшөөрөл болон энгийн зөвшөөрлийн мэдээллийн оруулж, цахим лавлагаа авах боломжтой | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | болсон. Мөн Зөвшөөрлийн цахим системээр дамжуулан дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, шинэ мэргэжлээр сургалт явуулах энгийн зөвшөөрлийн хүсэлт гаргах болон мэргэжлийн индексийн шинэчлэл, улсын тэмдэгтийн хураамж төлөх цэсийг хөгжүүлэх ажлын даалгавар боловсруулж системийн админтай хамтран хөгжүүлэлт хийж ажилласан. Хавсралт: 4 файл | | |
| 3.4.1 | Дээд боловсролын судалгааны ажлын хуулбарлалтыг шалгах нэгдсэн системийг хөгжүүлэх зохион байгуулалтаар хангана. | 300.00 | Цахим системийн хөгжүүлэлтийн хувь | 10 | 20 | 40 | Боловсролын сайдын 2025 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/55 дугаар тушаалын хавсралтаар "Судалгааны ажлын хуулбарлалтыг шалгах журам" батлагдсан. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 1/1711 тоот албан бичгээр тус журмыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянаад захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 7188 дугаарт бүртгэн ирүүлсэн. Дээд | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | боловсролын сургалтын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллагын багш, судлаач , суралцагчийн эрдэм шинжилгээ, судалгааны ажил, бүтээлийн хуулбарлалтын хувь хэмжээг тогтоох, судалгааны ажлын нэгдсэн мэдээллийн санг бий болгох, түүнийг ашиглахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулна. Журмыг дээд боловсролын байгууллага, эрдэм шинжилгээний судлаач, багш суралцагч, Шинжлэх ухаан, технологийн сан, цахим дэд бүтэц хариуцагч дагаж мөрдөнө. Шинжлэх ухаан, технологийн сангийн мэдээллийн сангийн цахим хөгжүүлэлтийн хувь 15-20 хувьтай байна. - Монгол Улсын Боловсролын яамны Дээд боловсролын газрын санаачилгаар төрийн өмчийн их сургуулиудын хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулж буй “Олон улсын шинжлэх ухааны мэдээллийн сангийн ашиглалт, түүний санхүүжилт, үр нөлөөг нэмэгдүүлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлгийг 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан. | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Энэхүү арга хэмжээнд Боловсролын яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Шинжлэх ухаан технологийн сан, Монголын номын сангуудын консорциумын удирдах зөвлөл, төр, хувийн хэвшлийн их, дээд сургуулийн төлөөлөл, номын сангуудын захирал, багш, судлаачид бүхий 22 байгууллагын 70 гаруй төлөөлөл оролцсон. Хэлэлцүүлгээр Төрийн өмчийн их сургуулийн номын сангуудын цахим мэдээллийн сангийн өнөөгийн байдал, хамтран ашиглах боломж, ШУТИС-ийн номын сангийн цахим мэдээллийн сангийн ашиглалт, туршлага илтгэлүүдийг хэлэлцүүлсэн. Хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллана.<br>Хавсралт: 2 файл | | |
| 3.4.2 | Дээд боловсролын салбарын цахимаар үзүүлж буй үйлчилгээний тоо, чанарыг | - | Цахим системийн хөгжүүлэлтийн хувь | 60 | 80 | 100 | Зөвшөөрлийн цахим систем бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд Боловсролын яамнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий дээд боловсролын сургалтын байгууллагын | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нэмэгдүүлж, лавлагаа, тодорхойлолтын санг хөгжүүлнэ. | | | | | | тусгай зөвшөөрөл болон энгийн зөвшөөрлийн мэдээллийн оруулж, цахим лавлагаа авах боломжтой болсон. Мөн Зөвшөөрлийн цахим системээр дамжуулан дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, шинэ мэргэжлээр сургалт явуулах энгийн зөвшөөрлийн хүсэлт гаргах болон мэргэжлийн индексийн шинэчлэл, улсын тэмдэгтийн хураамж төлөх цэсийг хөгжүүлэх ажлын даалгавар боловсруулж системийн админтай хамтран хөгжүүлэлт хийж ажилласан. Хавсралт: 3 файл | | |
| 3.5. | Дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, шинэ мэргэжлээр сургалт явуулах энгийн | - | - | - | - | | 1.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.2-д заасан их сургууль, коллежийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн 3 хүсэлт, мөн хуулийн 8.2 дугаар зүйлийн 6.2, 6.5-д заасан дээд боловсролын шинэ мэргэжлээр сургалт эрхлэх энгийн зөвшөөрлийн 29 хүсэлтийг тус тус Зөвшөөрлийн цахим системээр дамжуулан | 100% | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтаар хангана. | | | | | хүлээн авч, холбогдох баримт бичгийн бүрдлийг шалгаж, нөхөн бүрдүүлэх шаардлагатай баримт бичгийн мэдэгдэл хүргүүлэн, нөхөн бүрдүүлэлт хийлгээд системд шийдвэрлэлт үүсгэсэн. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/127 дугаар тушаалаар байгуулагдсан магадлан шалгах ажлын хэсгийн гишүүд чиг үүргийн дагуу баримт бичигйг хянаад гаргасан дүгнэлтийн үндэслэн Боловсролын сайдын нийт 7 тушаалаар 16 мэргэжлийн чиглэл, хөтөлбөрөөр сургалтын эрхлэх энгийн зөвшөөрөл олгоод байна. Магадлан шалгах ажлын хэсгээс хуульд заасан шаардлагыг хангасны дараа шинэ мэргэжил /хөтөлбөр/-ийн энгийн зөвшөөрлийн хүсэлтээ гаргах нь зүйтэй гэж дүгнэсэн энгийн зөвшөөрлийн 8 хүсэлтийг татгалзсан тухай мэдэгдэл хүргүүлсэн. Бусад хүсэлтийг шийдвэрлэхээр Боловсролын сайдын тушаалын төслийг боловсруулж, удирдлагуудад танилцуулж байна. 2.Дээд боловсролын | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургалтын байгууллагын хуулийн этгээдийн нэр өөрчлөгдсөнтэй холбоотойгоор тус сургалтын байгууллагын нэрийг өөрчлөх тухай нийт 2 хүсэлт ирүүлсэн. Хүсэлтийн бүрдэл, үндэслэлийг хянан үзсэний үндсэн дээр Боловсролын сайдын тушаалаар өмнө нь гаргасан холбогдох тушаалуудад өөрчлөлт оруулж, сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хавсралтыг өөрчлөн шинэчилж олгосон. 3.Дээд боловсролын сургалтын байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн 5 мэргэжлийн чиглэл (хөтөлбөр)-ийн сургалт эрхлэх энгийн зөвшөөрлийг Боловсролын сайдын тушаалаар хүчингүй болгосон, шийдвэрийг Зөвшөөрлийн цахим системийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулсан болно. | | |
| 3.5.1 | Дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай | - | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 2024 оны гүйцэтгэл | 50 | 100 | 1.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.2-д заасан их сургууль, коллежийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн 3 хүсэлт, мөн хуулийн 8.2 дугаар зүйлийн 6.2, 6.5-д | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зөвшөөрөл, шинэ мэргэжлээр сургалт явуулах энгийн зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгохтой холбоотой зохицуулалтыг гүйцэтгэнэ. | | | | | | заасан дээд боловсролын шинэ мэргэжлээр сургалт эрхлэх энгийн зөвшөөрлийн 29 хүсэлтийг тус тус Зөвшөөрлийн цахим системээр дамжуулан хүлээн авч, холбогдох баримт бичгийн бүрдлийг шалгаж, нөхөн бүрдүүлэх шаардлагатай баримт бичгийн мэдэгдэл хүргүүлэн, нөхөн бүрдүүлэлт хийлгээд системд шийдвэрлэлт үүсгэсэн. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/127 дугаар тушаалаар байгуулагдсан магадлан шалгах ажлын хэсгийн гишүүд чиг үүргийн дагуу баримт бичгийг хянаад гаргасан дүгнэлтийн үндэслэн Боловсролын сайдын нийт 7 тушаалаар 16 мэргэжлийн чиглэл, хөтөлбөрөөр сургалтын эрхлэх энгийн зөвшөөрөл олгоод байна. Магадлан шалгах ажлын хэсгээс хуульд заасан шаардлагыг хангасны дараа шинэ мэргэжил /хөтөлбөр/-ийн энгийн зөвшөөрлийн хүсэлтээ гаргах нь зүйтэй гэж дүгнэсэн энгийн зөвшөөрлийн 8 хүсэлтийг татгалзсан тухай мэдэгдэл хүргүүлсэн. Бусад | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүсэлтийг шийдвэрлэхээр Боловсролын сайдын тушаалын төслийг боловсруулж, удирдлагуудад танилцуулж байна. 2.Дээд боловсролын сургалтын байгууллагын хуулийн этгээдийн нэр өөрчлөгдсөнтэй холбоотойгоор тус сургалтын байгууллагын нэрийг өөрчлөх тухай нийт 2 хүсэлт ирүүлсэн. Хүсэлтийн бүрдэл, үндэслэлийг хянан үзсэний үндсэн дээр Боловсролын сайдын тушаалаар өмнө нь гаргасан холбогдох тушаалуудад өөрчлөлт оруулж, сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хавсралтыг өөрчлөн шинэчилж олгосон. 3.Дээд боловсролын сургалтын байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн 5 мэргэжлийн чиглэл (хөтөлбөр)-ийн сургалт эрхлэх энгийн зөвшөөрлийг Боловсролын сайдын тушаалаар хүчингүй болгосон, шийдвэрийг Зөвшөөрлийн цахим системийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулсан болно.<br>Хавсралт: 3 файл | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.6. | Дээд боловсролын сургалтын байгууллагын хөгжил, үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангах | - | - | - | - | 1. Засгийн газрын 2024 оны “Техникийн зохицуулалт батлах тухай” 253 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад тавих техникийн зохицуулалт”-ын дагуу дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох шалгуур үзүүлэлтийг баталгаажуулж, ангилал тогтоох ажлын хэсгийн дүгнэлтийг гарч, тушаал танилцуулсан. 2. Дээд боловсролын тухай хууль болон “Дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн нийтлэг дүрэм”-ийн хүрээнд удирдах зөвлөлүүд чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Боловсролын сайдын 2025 оны "Шинжлэх ухааны академийн их сургуулийн Удирдах зөвлөлийн үүсгэн байгуулагчийн төлөөллийг шинэчлэн батлах тухай" А/184, "Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Технологийн коллежийн Удирдах зөвлөлийн үүсгэн байгуулагчийн төлөөллийг шинэчлэн батлах тухай" А/185, Боловсролын | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сайдын 2025 оны " Тушаалд өөрчлөлт оруулах тухай” А/49, Боловсролын сайдын 2025 оны "Соёл урлагийн их сургуулийн Удирдах зөвлөлийн үүсгэн байгуулагчийн төлөөллийг шинэчлэн батлах тухай" А/44, Боловсролын сайдын 2025 оны "Монгол Улсын консерваторын сургуулийн Удирдах зөвлөлийн үүсгэн байгуулагчийн төлөөллийг шинэчлэн батлах тухай" А/18 дугаар, Боловсролын сайдын 2025 оны " Монгол Улсын консерваторын харьяа Завхан аймаг дахь хөгжим бүжгийн коллежийн Удирдах зөвлөлийн үүсгэн байгуулагчийн төлөөллийг шинэчлэн батлах тухай" А/08 дугаар тушаалууд батлагдан гарсан. Зарим их сургуулийн Удирдах зөвлөлөөс Боловсролын сайдын 2024 оны “Нийтлэг журам батлах тухай” А/331 дүгээр тушаалаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын эндаументын сангийн бүрдүүлэлт болон зарцуулалттай холбогдох нийтлэг журам”-ын 5.2 дахь хэсгийг хасах” санал ирүүлсэн. Журамд өөрчлөлт оруулах санал боловсруулан | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Боловсролын яамны вэб сайтад байршуулан олон нийтээс санал авч байна.<br>Хавсралт: 5 файл | | |
| 3.6.2 | Дээд боловсролын сургалтын байгууллагад тавих техникийн зохицуулалтын дагуу дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох үйл ажиллагааг зохион байгуулна. | 19,505,500 | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Засгийн газрын 2024 оны 253 дугаар тогтоол | 50 | 100 | Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/03 дугаар тушаалаар байгуулагдсан дээд боловсролын сургалтын байгууллагын ангиллыг тогтоох, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, Засгийн газрын 2024 оны “Техникийн зохицуулалт батлах тухай” 253 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад тавих техникийн зохицуулалт”-ын дагуу удирдамжийн хавсралтад тусгагдсан 17 дээд боловсролын сургалтын байгууллагын шалгуур үзүүлэлтийг баталгаажуулах ажлыг 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 01-ний хооронд зохион байгуулсан. Ажлын хэсгийн ахлагчийн баталсан чиг үүргийн хуваарийн дагуу 17 дээд боловсролын сургалтын байгууллагын | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ангилал тогтоох шалгуур үзүүлэлтийн үнэлгээг нэгтгэж, ангилал тогтоох ажлын хэсгийн дүгнэлтийг боловсруулж ажлын хэсгийн ахлагчаар баталгаажуулж, 2025.05.07-ны өдөр Дээд боловсролын зөвлөлийн хуралдаанд танилцуулсан, 2025.05.15, 16-ны өдөр дээд боловсролын сургалтын байгууллагуудад дүгнэлтийг танилцуулж, сонсох ажиллагаа зохион байгуулж, Боловсролын сайдын 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн тушаалаар баталгаажуулсан. Хавсралт: 3 файл | | |
| 3.6.1 | Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн төрийн төлөөллийг томилох тушаал батлуулж, удирдлага, зохицуулалтаар хангана. | - | Сайдын тушаал | Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/188 дугаар тушаал | Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн төрийн төлөөллийг томилж, удирдлага зохицуулалтаар хангасан байна. | Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн төрийн төлөөллийг томилж, удирдлага зохицуулалтаар хангасан байна. | Дээд боловсролын тухай хууль болон “Дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн нийтлэг дүрэм”-ийн хүрээнд удирдах зөвлөлүүд чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Боловсролын сайдын 2025 оны "Шинжлэх ухааны академийн их сургуулийн Удирдах зөвлөлийн үүсгэн байгуулагчийн төлөөллийг шинэчлэн батлах тухай" А/184, "Шинжлэх ухаан, | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | технологийн их сургуулийн харьяа Технологийн коллежийн Удирдах зөвлөлийн үүсгэн байгуулагчийн төлөөллийг шинэчлэн батлах тухай" А/185, Боловсролын сайдын 2025 оны " Тушаалд өөрчлөлт оруулах тухай" А/49, Боловсролын сайдын 2025 оны "Соёл урлагийн их сургуулийн Удирдах зөвлөлийн үүсгэн байгуулагчийн төлөөллийг шинэчлэн батлах тухай" А/44, Боловсролын сайдын 2025 оны "Монгол Улсын консерваторын сургуулийн Удирдах зөвлөлийн үүсгэн байгуулагчийн төлөөллийг шинэчлэн батлах тухай" А/18 дугаар, Боловсролын сайдын 2025 оны " Монгол Улсын консерваторын харьяа Завхан аймаг дахь хөгжим бүжгийн коллежийн Удирдах зөвлөлийн үүсгэн байгуулагчийн төлөөллийг шинэчлэн батлах тухай" А/08 дугаар тушаалууд батлагдан гарсан. Зарим их сургуулийн Удирдах зөвлөлөөс Боловсролын сайдын 2024 оны "Нийтлэг журам батлах тухай" А/331 дүгээр тушаалаар батлагдсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын эндаументын | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сангийн бүрдүүлэлт болон зарцуулалттай холбогдох нийтлэг журам"-ын 5.2 дахь хэсгийг хасах" санал ирүүлсэн. Журамд өөрчлөлт оруулах санал боловсруулан Боловсролын яамны вэб сайтад байршуулан олон нийтээс санал авч байна. Хавсралт: 5 файл | | |
| Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | | | |
| 4.1. | Төрийн захиргааны төв байгууллагын болон харьяа байгууллагын хүний нөөцийн удирдлагын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг хангах, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллана. | - | - | - | - | | Иргэд олон нийтэд төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох, батлагдах дүрэм, журамд олон нийтийн саналыг зорилгоор дараах арга хэмжээнүүдэд авч ажилласан. 1.Батлагдсан дүрэм журам, тушаалыг олон нийтэд хүргэх танилцуулах хүрээнд мэдээлэл бэлтгэж, хэвлэлийн албанд өгч ажилласан. Үүнд: Босго оноонь тушаалын танилцуулга, Эрүүл мэндийн сайд болон Боловсролын сайдын хамтарсан тушаалаар батлагдсан "Эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт хамтрагдах журам" | 100% | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | танилцуулга мэдээллийг бэлтгэж өгсөн. 2.Захиргааны ерөнхий хуулийн холбогдох заалтуудыг хангах хүрээнд "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага" -ын төслийг Боловсролын яамны сайтад /https://moe.gov.mn/post/162782/ байршуулан 546 үзэлттэй иргэд олон нийтээс саналыг авч журмыг батлуулсан. 3.Иргэд олон нийт, дээд боловсролын салбарт элсэгчдийг шаардлагатай мэдээллээр нээлттэй хангуулах хүрээнд дээд боловсролын сургалтын байгууллагуудад БЯ-ны 2025 оны 4/2349 дугаартай албан бичгийг сургуулиудад хүргүүлж ажилласан. 4.Дээд боловсролын салбарын үйл ажиллагаа, мэдээ мэдээллийг иргэд олон нийтэд хүргэж танилцуулах хүрээнд МҮОНТ-ийн нээлттэй хэлэлцүүлэгт, Монголын радио, оюутны эрүүл мэндийн үзлэг оншлогооны асуудлаар 3 сайт, 2 тв-д ярилцага | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мэдээлэл өгсөн. 5. Боловсролын зээлийн сангаар олгох зээл, тэтгэлэг, тусламжтай холбоотой журмын танилцуулгыг БЗС-тай хамтран хийсэн. | | |
| 4.1.1 | Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана. | Үйл ажиллагааны зардлаар | Мэдээллийн тоо | 2024 оны гүйцэтгэлийн түвшингээр | Хуульд заасан бүх мэдээлэл байршсан байна. | Хуульд заасан бүх мэдээлэл байршсан байна. | Иргэд олон нийтэд төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох, батлагдах дүрэм, журамд олон нийтийн саналыг зорилгоор дараах арга хэмжээнүүдэд авч ажилласан. 1.Батлагдсан дүрэм журам, тушаалыг олон нийтэд хүргэх танилцуулах хүрээнд мэдээлэл бэлтгэж, хэвлэлийн албанд өгч ажилласан. Үүнд: Босго онооны тушаалын танилцуулга, Эрүүл мэндийн сайд болон Боловсролын сайдын хамтарсан тушаалаар батлагдсан "Эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт хамтрагдах журам" танилцуулга мэдээллийг бэлтгэж өгсөн. 2.Захиргааны ерөнхий хуулийн холбогдох заалтуудыг хангах хүрээнд "Аж ахуйн нэгжийн орлогын | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | албан татварын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага" -ын төслийг Боловсролын яамны сайтад /https://moe.gov.mn/post/162782/ байршуулан 546 үзэлттэй иргэд олон нийтээс саналыг авч журмыг батлуулсан. 3.Иргэд олон нийт, дээд боловсролын салбарт элсэгчдийг шаардлагатай мэдээллээр нээлттэй хангуулах хүрээнд дээд боловсролын сургалтын байгууллагуудад БЯ-ны 2025 оны 4/2349 дугаартай албан бичгийг сургуулиудад хүргүүлж ажилласан. 4.Дээд боловсролын салбарын үйл ажиллагаа, мэдээ мэдээллийг иргэд олон нийтэд хүргэж танилцуулах хүрээнд МҮОНТ-ийн нээлттэй хэлэлцүүлэгт, Монголын радио, оюутны эрүүл мэндийн үзлэг оншлогооны асуудлаар 3 сайт, 2 тв-д ярилцага мэдээлэл өгсөн. 5. Боловсролын зээлийн сангаар олгох зээл, тэтгэлэг, тусламжтай холбоотой журмын | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | танилцуулгыг БЗС-тай хамтран хийсэн. Хавсралт: 2 файл | | |
| 4.2. | Урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн болон үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, архив, албан хэрэг хөтлөлт, дотоод үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, байгууллагын соёлыг төлөвшүүлнэ. | - | - | - | - | | Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө зэрэг урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан дээд боловсролын салбарт хамаарах арга хэмжээг газрын болон чиг үүргийн дагуу хариуцсан албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангуулж, биелэлтийг хугацаанд нь Төрийн мэдээллийн сүлжээ цахим системээр тайлагнасан. Дээд боловсролын сургалтын байгууллагын орчинд шударга ёсны үзэл санааг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах, багш, ажилтан, суралцагчдад авлигаас ангид, ёс зүйтэй байхыг уриалсан, авлига, | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | түүний хор уршгийг таниулах, нийгэмд эерэг хандлагыг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээ зохион байгуулах чиглэлийг Төрийн нарийн бичгийн даргын 2025.04.17-ны 2/1573 тоот албан бичгээр хүргүүлсэн. Дээд боловсролын сургалтын байгууллагаас “АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНЫ ХЭЛТЭС”-тэй хамтран "Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, мэдлэг олгох сургалт", сургууль бүр сургуулийн орчиндоо өдөрлөг арга хэмжээ зохион байгуулсан.<br>Хавсралт: 3 файл | | |
| 4.2.1 | Урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах | Үйл ажиллагааны зардлаар | Биелэлтийн хувь | 2024 оны гүйцэтгэлийн түвшингээр | 100 | 100 | Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө зэрэг урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дээд боловсролын салбарт хамаарах арга хэмжээг газрын болон чиг үүргийн дагуу хариуцсан албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангуулж, биелэлтийг хугацаанд нь Төрийн мэдээллийн сүлжээ цахим системээр тайлагнасан. Дээд боловсролын сургалтын байгууллагын орчинд шударга ёсны үзэл санааг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах, багш, ажилтан, суралцагчдад авлигаас ангид, ёс зүйтэй байхыг уриалсан, авлига, түүний хор уршгийг таниулах, нийгэмд эерэг хандлагыг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээ зохион байгуулах чиглэлийг Төрийн нарийн бичгийн даргын 2025.04.17-ны 2/1573 тоот албан бичгээр хүргүүлсэн. Үүний хүрээнд дээд боловсролын сургалтын байгууллагаас “АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНЫ ХЭЛТЭС”-тэй хамтран "Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, мэдлэг олгох | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургалт"-ыг зохион байгуулсан.<br>Хавсралт: 8 файл | | |
| 4.2.2 | Авлигыг үл тэвчих ёс суртахууныг төлөвшүүлэх сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн оюутнуудад авлигыг үл тэвчих хандлагыг бий болгоход чиглэсэн сургалтыг зохион байгуулах | - | Сургалтын тоо | Боловсролын сайдын 2024 оны 10 сарын 10-ны өдрийн А/137 дугаар тушаал | Хэрэгжилт хангагдсан байна. | Хэрэгжилт хангагдсан байна. | Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө зэрэг урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан дээд боловсролын салбарт хамаарах арга хэмжээг газрын болон чиг үүргийн дагуу хариуцсан албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангуулж, биелэлтийг хугацаанд нь Төрийн мэдээллийн сүлжээ цахим системээр тайлагнасан. Дээд боловсролын сургалтын байгууллагын орчинд шударга ёсны үзэл санааг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах, багш, ажилтан, суралцагчдад авлигаас ангид, ёс зүйтэй байхыг уриалсан, авлига, | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | түүний хор уршгийг таниулах, нийгэмд эерэг хандлагыг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээ зохион байгуулах чиглэлийг Төрийн нарийн бичгийн даргын 2025.04.17-ны 2/1573 тоот албан бичгээр хүргүүлсэн. Үүний хүрээнд дээд боловсролын сургалтын байгууллагаас “АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНЫ ХЭЛТЭС”-тэй хамтран "Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, мэдлэг олгох сургалт"-ыг зохион байгуулсан. Энэхүү сургалт нь авлигын талаарх суурь ойлголтыг гүнзгийрүүлэх, оюутан залуусын ёс зүй, хариуцлагыг төлөвшүүлэх, иргэний оролцоог идэвхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Дээд боловсролын сургалтын байгууллага бүр шударга ёсны үзэл санааг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр сургалтын байгууллага бүрдээ багш, ажилтан, оюутнуудыг хамруулсан өдөрлөг арга хэмжээ зохион байгуулсан нь зөвхөн хууль зөрчсөн үйлдэл бус, улс орны хөгжлийн саад, шударга | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ёсны эсрэг том аюул болохыг ухааруулсан энэхүү сургалт нь ёс суртахуунтай, хариуцлагатай иргэн төлөвших боловсролын үйл явцын нэг хэсэг болж чадсан. Дээд боловсролын сургалтын байгууллагад Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрт туссан ажлыг үе шаттайгаар зохион байгуулсан тухай тайланг авч нэгтгэн Боловсролын яамнаас хагас жил тутамд Авлигатай тэмцэх газарт тайлан хүргүүлж ажиллаж байна.<br>Хавсралт: 3 файл | | |

*Үнэлсэн:* .........................

*..........................................* *.........................* */................................/*

*(албан тушаал )* *(гарын үсэг)*

*.........................*

*(огноо)*

*Тайлагнасан:* .........................

*..........................................* *.........................* */................................/*

*(албан тушаал )* *(гарын үсэг)*

.........................

*(огноо)*